

Гар бичмэл, монгол судлалын сан хөмрөгийн танилцуулга
“Богд ламын зохиолын хувь зүйл нэгээс
үүсгэн туурвиж шашны үүдийг нээгч
хэмээгдэх оршивай

Энэ удаа та бүхэнд VIII богд Жавзандамбын амаар айлдсаныг Дарамбазар бичсэн тус зохиолын модон хэв ба модон хэвээр хэвлэсэн номын тухай товчхон өгүүлэх болно. Үүнд:

Номын монгол үсгийн модон хэвийн тухай товчхон

Энэхүү номын модон хэв нь Монголын Үндэсний Номын Сангийн Гар бичмэл, монгол судлалын сан хөмрөг; Төвд номын сан хөмрөг; Үнэт ховор номын музейн үзмэрийн танхимд тус тус хадгалагдаж байна. Үүнээс гадна Гар бичмэл, монгол судлалын номын сан хөмрөгт хэвлэж дэвтэрлэсэн ном нь уг эхээрээ байдаг. Энэ хэв нь харьцангуй бүрэн бүтнээрээ бидний үед хүрэлцэн ирсэн хэвүүдийн нэг юм. Хус модон дээр 2 баганад 24 мөрөөр сийлсэн. Номын хоёр нүүрийг нэгэн хэвийн хавтсанд багтаан сийлсэн онцлогтой.

Барыг Ганданшаддүвлин хийдэд бүтээсэн. Хадгалж байсан газар нь Богдын Эх дагинын аймаг юм.

Өргөн 18.3 см, урт 40.8 см, зузаан 25 см.

Номын тухай товчхон

Энэ ном нь нэлээд сонирхол татахуйц бүтээлүүдийн нэг юм. Учир юун хэмээвээс монголын 8-р богд Жавзандамба хутагтын зохиосон бүтээл бөгөөд энэ бүтээлдээ монголын 20-р зууны эхэн үеийн ороо бусгаа байдлыг тун сонирхолтойгоор дурдсан байна. Энэ бүтээлээс доор зарим нэгэн хэсгээс хэсэгчлэн сийрүүлбэл:

Тус зохиолын эхлэлд Наймдугаар богдын төвд нэрийг нь монгол хэлээр орчуулан бичжээ. Үүнийг сийрүүлбэл “Богд лам түгээмлийн эзэн очирдара зарлигийн **эрхэт сайн оюут богд номын их наран алдарт**¹ шашныг барин тэтгэгч багш шавь цөмийн оройн чимэгт эрх баялаг найм төгөлдөр богд гэгээн сансрын эцэс хүртэл ялгах болтугай...”.

Мөн гамин хэмээх нэрийн утгыг энэ зохиолдоо “...Амьтны дуун зохилдсон хорлогдогч ба хорлолыг үйлдэгчинд барилдсан муу үйлс боловсорсны эрхээр өөр бусдыг хутган үйлдэгч Гэминда хэмээсэн нэр тэр хар Хятадын хэл тэр нь өөрийн амийг хайрлахгүй хэмээсэн утгатай мөн бөгөөд хэл сунжирснаас монголын хэлэнд гамин хэмээн нийтэд алдаршсан...” хэмээн ийнхүү тайлбарласан байна.

Барон Унгерний тухай “Их хүрээ голлон үйлдэж Халх гүрний орон бүхнийг гэмингээр дүүрэх болсноос цэргээр бүсэлж сүйтгэхүйг завдаж үйлдсэнд, богд эзэн хаан ч хаан төрд эрхээр урвуулсан эрхээ булаагдахын ёсыг үзүүлэх болбоос бус хад түшмэл албат иргэн нугууд эрх үгүй болсныг өгүүлэх юун хэрэг. Тэр мэт ёсоор сар хэр өнгөрсний үед Барон жанжин хэмээх урьд дасаагүй таньж үл мэдэх шар оросын хаан гүрний дотор багтсан нэгээр цэргийн ноён ихээр голлож үйлдсэн хэлний зүйл адилгүй олон цугласан

¹ VIII богдын нэрийг монголчлон орчуулсан.

цэрэг олон ирснээс богд ламын гэгээнд зөрчих ба шашин хийгээд амьтанд хорлон хөнөөж үйлдэх гамингийн дайныг дарсан...” гэж тэмдэглэсэн байна.

Богд хааныг хаан ширээнд хаана залсан, тухайн үед цагийн байдал ямар байсан тухай өгүүлэхдээ “...Тэр мэтийн ёсоор шажны дайсан тэдгээрийн буяныг барснаас чөлөө олохын цаг зэрэгт урьдын Барон жанжин голлон үйлдсэн ачит олон цэрэг ирснээс Богд лам эзэн хааныг Манзушир ламын хийдэд залсан бөгөөд тэр үед гэмингийн цэргийн чуулганаар одоо дахин сүйтгэж үйлдэхийн хорлол тасрал үгүй Богдын гэгээний орд харш Шаравпэлжэйлинд хоёр хоног хүртэл үхэр буугаар уулын оройноос ч буудав. Ойр орчмын ч газраас буудав. Гандан хүрэнүүдийг ч үхэр буугаар буудав... тэр мэт маш аймшигтай болсны байр байцаар орд харш хийд балгад сэлтийг сүйтгэхийн тул нэн шамдсан боловч юунд ч хорлолыг хүргэж чадсан үгүйд хоёр хоног хиртэй болсны шөнө дундад хүрвээс богд лам эзэн хааны алтан цэргийн чуулган эдгээрийн анхнаас дайсны цэрэг эдгээрийн тоо зуун хувь хуваасны нэг хувиас ч цөөхөн нэг иргэд...” гэжээ.

Энэ номын төгсгөл үгэнд:

“... Богд Очирдара ламын зохиосон гишүүний хувь зарим нэгнээс туурвин зохиосон шашны үүдийг нээгч хэмээсэн үүнийг нь,

Дэргэд шадар бараа бологч нягт билигт Да лам Пунцагдорж хийгээд Дэчэнгалбагийн шавьд орсон үйзэн гэлэн Чагдар хоёроор тэнгэрийн эдлэл ариун цагаан хадаг мөнгөний өргөл сэлт дуртган айлтгасны нүүрт зарлигийн ач тэнцэш үгүй лам богд ринбочийн зарлигийг оройгоор хүлээн авсан бөгөөд багш садан дээдэс олны үлэмжийн тоосыг оройгоор шүтсэн Дарамбазар хэмээх нэрт нэгэн бээр дээд мэргэд гэгээний зарлигийг даган дуурайж үйлдсэнээс равжун арван тавдугаар он Лүй ан рүй бал(мо. Муу биет яст мэлхий) /1920 он/ хэмээх жилийн шинийн хоёрын санбо данба(мо. Анхдугаар сайн) хэмээх сайн өдрөө Рибодагжай Ганданшаддүвлинд эвсүүлсэн сайн буян арвидах болтугай хэмээн шашны үүдийг нээгч хэмээгдэх монгол төвд хоёуланы хэв энэ ямагтыг Эх дагинын гэгээнээр бүтээсний буянаар богд ламын гэгээнээр голлон үйлдсэн шашныг баригч дээдэс нугуудын үлэмж лянхуа батадаад бурхны шашин зүг цаг бүхэнд өрнөн дэлгэрэхүйд өнө удаан гийж оршихуйн угт болох болтугай. Буян болой.

Сарва мангалам

Хэв үүнийг Эх дагинын аймагт тавибай.” хэмээн бичсэн байдаг.

Тус номыг 2858/96, 3422/96-3423/96, 3434-3436/96 дансны дугааруудаас захиалан үзэж болно.

Бэлтгэсэн: МҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөгч Ч.Гансүх